

Монголын сэтгүүл зүйн боловсрол: Өөрчлөлт

Даваадоржийн Дагиймаа 

Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

✉ d_dagiimaa@humanities.mn

Хураангуй: Энэ судалгаа нь Монгол Улсад сүүлийн арван жилд сэтгүүлч мэргэжлээр элсэлт буурсан, энэ чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын мэргэжлээрээ ажиллах сонирхол буурсан шалтгааныг илрүүлэх зорилготой юм. Сэтгүүлчээр суралцаж байгаа оюутнуудын сүүлийн таван жил дэх тоон мэдээлэлд шинжилгээ хийхээс гадна сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулийн давхардсан тоогоор 426 оюутнаас онлайнаар 2020, 2023 онд мэргэжлийн үнэлэмжийн судалгааг асуулгын аргаар авч дүгнэлт гаргалаа. Сэтгүүлч мэргэжлийн нэр хүнд унаж, цалин багатай, цагийн дарамт ихтэй ажил гэж ойлгогдох болсон нь гол шалтгаан байв. Үүнээс гадна нийгмийн зүгээс сэтгүүлчдэд ирэх сошиал хүчирхийлэл сэтгүүлчээр суралцагч оюутнуудад томоохон сорилт болжээ. Иймд ажлын байр хангалттай байгаа ч хөдөлмөрийн нөхцөлөөс хамаараад хүний нөөцийн хомсдолд орсон салбар болж байна.

Харин сэтгүүл зүйн сургуулиуд хоёр талдаа бэрхшээлтэй тулгарч байна. Нэг талаараа дижитал хувьсгал уламжлалт мэдээллийн хэрэгслийг хүчээр шахаж байгаа тул оюутны тоо мэдэгдэхүйц буурч байна. Нөгөө талаар, сэтгүүл зүйн сургуулиудад оюутнууд өргөн хүрээний мултимедиа ур чадварыг эзэмшүүлэхийг шаардаж, нэгэн зэрэг олон платформд агуулга хүргэх шинэ хэлбэрийн сэтгүүл зүйн чиглэлээр мэргэшсэн төгсөгчдийг ажилд авах эрэлт улам бүр нэмэгдэж байна.

Түлхүүр үгс: сэтгүүл зүйн дээд боловсрол, хэрэгцээ шаардлага, сорилт боломж, мэргэжлийн үнэлэмж

Mongolian journalism education: Changes

Dagiimaa Davaadorj 

University of the Humanities, Ulaanbaatar, Mongolia

✉ d_dagiimaa@humanities.mn

Abstract: This study aims to identify the reasons for the declining enrollment in journalism programs in Mongolia over the past decade, as well as the decreasing interest among students in pursuing careers in journalism. In addition to analyzing enrollment data from the past five years, the study conducted online surveys in 2020 and 2023 to assess students' perceptions of the journalism profession. A total of 426 students from journalism departments across several universities participated in the survey.

The results indicate that the declining reputation of journalism as a profession, combined with low salaries and intense time pressures, are key factors discouraging students from entering the field. Furthermore, social media-based harassment and public criticism of journalists have emerged as major challenges for journalism students. Despite the availability of jobs in the sector, unfavorable working conditions have contributed to a shortage of human resources.

Journalism schools are facing a dual challenge. On the one hand, the digital transformation is rapidly displacing traditional media outlets, leading to a noticeable decline in student enrollment. On the other hand, there is growing demand in the job market for graduates who are equipped with a wide range of multimedia skills and are capable of producing journalism across multiple platforms. As a result, journalism programs are under pressure to modernize their curricula and prepare students for the demands of a convergent media environment.

Keywords: *higher journalism education, needs, challenges, opportunities, and professional values*

Оршил

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрх баригч нэг намын үзэл суртлыг сурталчлахад чухал үүрэг гүйцэтгэж байсан 1980-аад оны сүүлээр манай улсад 1 телевиз, 1 радио, 37 сонин, 32 сэтгүүл тогтмол үйл ажиллагаа явуулж байв (Норовсүрэн 2003). 1990 онд Монгол Улс ардчилсан орон болсноор хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, агуулгад тавих төрийн хяналт үгүй болж, хэвлэл мэдээллийн байгууллагын тоо хурдацтай нэмэгдэж, богино хугацаанд 663-д хүрсэн (Зулькафиль 2014). Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлд дээд мэргэжилтэй боловсон хүчний эрэлт хэрэгцээ их болсон учир хувийн хэвшлийн оролцоог дээд боловсролын салбарт хуульчилж өгсөн юм. Улсын их, дээд сургуулиуд өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоонд шилжсэнээр оюутнууд сургалтын төлбөр төлж, хувийн их дээд сургуулиудын тоо ч нэмэгдсэн. Судалгаагаар 1991 онд 20,000 оюутантай улсын 14 их сургууль байсан бол 2009 он гэхэд энэ тоо 151 (эдгээрийн 42 нь улсын их сургууль) болж, нийт 150,326 оюутанд хүрчээ (Дэлхийн банк 2013).

1913 онд үүссэн Монголын сэтгүүл зүйн салбарт 1960-аад он хүртэл сэтгүүл зүйд бичиж туурвих сонирхолтой, байгалиас заяасан авьяастай, бие даан, эсвэл дагалдан суралцсан эсвэл богино хугацааны курс дугуйлан төгссөн хүмүүс ажиллаж байв. Өөрөөр хэлбэл, монголын сэтгүүл зүй анх манай соёлын өв, монгол оюун ухаанд тулгуурлан хөгжиж ирсэн. 1950-аад оны дунд үеэс монголын сэтгүүлчид Москва, Ленинград, Болгар, Зүүн Германд боловсрол эзэмших болов. Ийнхүү 1950-1960-аад оны дунд үеэс шинээр төгссөн, өндөр боловсролтой сэтгүүлчид эх орондоо ирж ажиллах болсон нь монголын сэтгүүл зүйн практикт шинжлэх ухааны арга зүйг нэвтрүүлэх хөшүүрэг болсон юм. Эдгээр сэтгүүлчид үндэсний боловсон хүчин бэлтгэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан (Норовсүрэн 2001).

МУИС-д 1960-1961 оны хичээлийн жилд сэтгүүл зүйн чиглэлээр элсэлт авч нэг жилийн дараа сэтгүүл зүйн тэнхим байгуулагдсан юм. Дөрвөн жилийн дараа сэтгүүлчийн ангийг 30 оюутан төгссөн нь монголын анхны сэтгүүлч мэргэжилтэй

үндэсний боловсон хүчин байлаа. Ийнхүү 4 жил төгсөлт хийсний дараа 1967 онд МАХН-ын Төв хорооны дэргэдэх Намын дээд сургуульд Сэтгүүл зүйн тэнхим шилжүүлсэн юм (Сэтгүүл зүй олон нийтийн харилцааны тэнхим 2020). 1971-1976 онд 6 төгсөлт хийж 100 гаруй сэтгүүлч бэлтгэсэн байна. Мөн Улаанбаатар хотын Намын хорооны дэргэдэх Марксизм-Ленинизмийн их сургуульд гурван жилийн сургалттай сэтгүүлчийн оройн ангид нийт долоон удаа элсэлт авч, зургаан удаагийн төгсөлт хийжээ. 1978 онд МУИС-д сэтгүүлчийн ангийг дахиж нээж дараа жил нь Сэтгүүлчийн тэнхимийг байгуулсан байна. Тэр цагаас хойш 2020 он хүртэл МУИС 38 удаагийн төгсөлтөөр 1500 гаруй сэтгүүлчийг бэлтгэн гаргасан байна.

Судалгааны үр дүн

Дэлхий нийтийн боловсролын чиг хандлага 1990 оноос өмнө элитийн боловсролын шинжтэй байсан ба ба цөөн элсэгчтэй, чанартай цөөн хөтөлбөртэй байсан бол 1990 оноос хойш дээд боловсрол нь бүх нийтийн боловсролын чиг хандлагад шилжиж их, дээд сургуулийн тоо олширсон юм. Монгол Улсын хувьд 1991 онд улсын 14 их, дээд сургууль байсан бол, хувийн сургуулиуд бий болж 2006 онд 180 их, дээд сургуулиуд Монголд үйл ажиллагаа явуулж байлаа. Харин 1990 онд 1 их сургууль сэтгүүл зүйн боловсрол олгож байсан бол, 2006 онд 22 болж энэ тоо нэмэгдсэн юм. Монгол Улсад сэтгүүл зүйн чиглэлээр төгсөлтийн дараах боловсрол олгох үйл ажиллагаа 1996 оноос эхэлсэн тухай баримт бий. Энэ онд МУИС сэтгүүл зүйн чиглэрээр сургалт эхэлжээ. Мөн доктор профессор Л.Норовсүрэнгийн ярилцлагаас үзэхэд, 1995 онд сэтгүүл зүйн мэргэшсэн Эрдмийн зөвлөл байгуулагдаж, үүний үр дүнд 1996 онд анхны докторын зэрэг хамгаалалт явагдсан байна. Тэрээр өөрөө 1996 онд сэтгүүл зүйгээр докторын зэрэг хамгаалсан бөгөөд энэ үйл явдал нь Монголд сэтгүүл зүйн төгсөлтийн дараах боловсролын эхлэл болсон гэж үздэг (Отгонсүрэн 2017).

1965-2012 онд нийт 4609 сэтгүүлч бэлтгэж, энэ үед жилдээ 400 орчим мэргэжлийн сэтгүүлчийг төгсгөж байв. Тэд сэтгүүлч, олон улсын сэтгүүлч, сэтгүүлч-тайлбарлагч, сэтгүүлч-утга зохиолын ажилтан, радио, телевизийн сэтгүүлч, телевизийн сэтгүүлч-зураглаач, телевизийн сэтгүүлч - продюсер, спортын сэтгүүлч гэсэн мэргэжлээр мэргэшин суралцаж байв.

Хэвлэлийн хүрээлэнгийн тайлангаас үзвэл, 2012 онд Монгол Улсын 555 хэвлэл мэдээллийн байгууллагад 4903 хүн ажиллаж байснаас 2341 нь сэтгүүлч, сурвалжлагч, редактор, продюсер зэрэг уран бүтээлчид байсан бол, үлдсэн нь удирдах болон техникийн талын ажилтанууд байлаа (Монголын хэвлэлийн хүрээлэн 2013). Эдгээрээс мэргэжлээр нь авч үзвэл, 867 нь мэргэжлийн сэтгүүлч байсан.

Харин 2025 оны байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 61 их дээд сургуулиас 16 их, дээд сургууль сэтгүүл зүйн чиглэлээр сургалт явуулж байна. Ийнхүү сургуулийн тоо цөөрч, түүнд суралцаж байгаа оюутны тоо ч мөн буурсан байна.

Өнөөдөр 16 их, дээд сургуульд 723 оюутан сэтгүүлч мэргэжлээр суралцаж байна (Хүснэгт 1). 2016 онд 1749 оюутан 18 их дээд сургуульд сэтгүүл зүйн бакалаврын түвшинд суралцаж байсан бол 2019 онд энэ тоо 41,4 хувиар, 2023 онд 58,7 хувиар буурчээ.

Хүснэгт 1. Монголын сэтгүүл зүйн сургуулиудын суралцагчдын тоо, сүүлийн 5 жилээр¹

	2020-2021	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Нийт суралцагчид	1,188	1,107	971	973	1068
эрэгтэй	304	287	257	255	292
эмэгтэй	884	820	714	718	776
Бакалаврын боловсрол	981	878	751	754	850
эрэгтэй	242	218	185	181	222
эмэгтэй	739	660	566	573	628
Магистрын боловсрол	141	157	136	133	124
эрэгтэй	33	38	40	43	37
эмэгтэй	108	119	96	90	87
Докторын боловсрол	66	72	84	86	94
эрэгтэй	29	31	32	31	33
эмэгтэй	37	41	52	55	61

Доорх хүснэгтээс харахад, 10 хүрэхгүй оюутантай сэтгүүл зүйн хөтөлбөртэй 5 сургууль байна. Мөн 2022-2023 оны хичээлийн жилд 7 сургуульд 117 оюутан сэтгүүлчийн 1-р ангид элсэн суралцаж байна. 16 их, дээд сургууль сэтгүүлч бэлтгэж байгаа боловч эдгээрээс мэргэжлийн үндсэн багшгүй тэнхим 5 байна. Мөн МУИС, ХИС, МУБИС, РМТУС гэсэн төрийн өмчийн 3 сургууль, төрийн бус өмчийн нэг сургуульд элсэгчдийн тоо нэмэгдэж бусад нь буурчээ. Үүнийг томоохон их сургуулиуд БМИҮЗ-д хүргүүлсэн тайландаа “манай хөтөлбөрөөр суралцагсдын элсэлтийн дундаж оноо жил бүр 500-гаас их, элсэгчдийн тоо жил ирэх бүр өсөж байгаа нь манай хөтөлбөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ өндөр, нийгэмд хэрэгцээтэй, ажлын байраар хангагдах магадлал өндөртэй, сонирхол татаж байгаа мэргэжил гэдэг нь харагдаж байна” хэмээн дүгнэсэн нь өрөөсгөл юм. Харин үүнд нөлөөлсөн хамгийн том хүчин зүйл бол 2016-2017 оны хичээлийн жилээс элсэгчдийн хяналтын тоог тухайн сургуулийн удирдах зөвлөлийн шийдвэрээр тогтоодог болсноор төрийн өмчийн болон хувийн нэр хүнд бүхий томоохон сургуулиудын элсэгчдийн тоо нэмэгдэж нөгөө талд төрийн бус өмчийн сургуулийн хувьд элсэгчийн тоо огцом буурчээ.

Монгол Улсын хэмжээнд их сургуульд суралцагчдын тоо 20 хүртэл хувиар буураад байна. Энэ нь сүүлийн жилүүдэд монголын их, дээд сургуульд элсэх босго оноог нэмсэнтэй, мөн боловсролын гадагшаа чиглэсэн урсгалтай холбоотой юм. Ийнхүү элсэгчдийн тоо буурснаар 2016 оны байдлаар жилдээ 400 гаруй оюутан төгсдөг байсан бол өнөөдөр жилдээ 200 хүрэхгүй оюутан сэтгүүлч мэргэжлээр төгсөж байна (Dagiimaа 2016, 170-193).

¹ Эх сурвалж: БСШУЯ-ны Дээд боловсролын статистик

*Хүснэгт 2. Сэтгүүлч мэргэжлээр бакалаврын түвшинд
суралцагчдын тоо сургуулиар, 2025²*

Сургуулийн нэр	Сэтгүүл зүйн сургалт эхэлсэн он	2016-2017	2019-2020	2024-2025
МУИС	1960	215	180	314
ХИС	1994	116	172	75
МУБИС	1991	230	226	147
РТМУС	1995	323	218	100
Отгонтэнгэр ИС	1998	105	29	13
Идэр ИС	2000	55	29	20
Зохиомж ДС	1999	188	8	93
Кино урлагийн ДС	1999	82	20	11
Улаанбаатар эрдэм ДС	1997	48	8	3
Их засаг их сургууль	2002	61	50	9
Сэтгүүлч коллеж/ Сити ДС	2004	82	5	15
Утга зохиол, нийгмийн ажилтны ДС	1997	30	5	-
МПУ	2018	-	30	12
МУИС	2016	-	35	31
Улаанбаатар дээд сургууль	2006	44	-	-
ХИС-ийн Дархан салбар сургууль	2012	30	-	-
Орхон ИС	2009	17	-	-
Соёл эрдэм ДС	2003	40	-	-
Олон улс судлалын ДС	1996	24	-	7
Их Монгол ДС /Глобаль удирдагч ДС/	1999	59	-	-
Нийт		1749	1015	850

Сэтгүүл зүйн сургуулиудад ахисан түвшинд суралцаж буй оюутнуудыг нь авч үзвэл, докторын сургалтыг 3, магистрын түвшинд 7 сургуульд нийт 219 суралцагч байна.

Дэлхий нийтэд их, дээд сургуульд элсэгчдийн тоо буурсан ба сэтгүүл зүйн салбар ч үүнээс тойроогүй юм. Судалгаанаас үзвэл, сэтгүүл зүй, олон нийтийн мэдээлэл харилцааны бакалаврын хөтөлбөрт хамрагдах оюутнууд 2010-2013 онд АНУ-д 3 хувиар буурсан байна. Харин 2013 оныг өмнөх оныхтой харьцуулахад, олон нийттэй харилцах, зар сурталчилгааны чиглэлээр оюутнуудын хувь бараг өөрчлөгдөөгүй байна (Becker Lee B, Vlad Tudor, Simpson Holly 2014, 345). Дараагийн жилүүдэд сэтгүүл зүйн хөтөлбөрүүдэд улам бүр хүнд цохилт ирсэн юм. Техасын Технологийн их сургуулийн 2017 онд гаргасан судалгаагаар 2013-2015 оны хооронд улсын хэмжээнд энэ чиглэлээрх бакалаврын элсэлт 16.3 хувиар

² Эх сурвалж: БСШУЯ-ны бүртгэлийн систем

буурчээ. Ийнхүү сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны чиглэлээр оюутны сонирхол буурчээ. 1990-ээд оны эхэн үед үндэсний хэмжээнд бакалаврын түвшний элсэлт буурсан нь эдийн засаг суларсантай холбоотой. Энэ удаад эдийн засаг сэргэлтэд байснаараа ялгаатай байв.

Харин Олон нийттэй харилцах мэргэжлийн бакалаврын элсэлт 2013 оноос хойш тодорхой хэмжээгээр өссөн байна (Melissa R. Gotlieb, Bryan McLaughlin, R. Glenn Cummins 2017). Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны чиглэлээр суралцдаг 10 оюутан тутмын долоо нь зар сурталчилгаа, олон нийттэй харилцах чиглэлээр суралцаж байгаа нь сүүлийн 20 гаруй жилийн турш үргэлжилсэн судалгаа юм. 2015-2018 онд АНУ-д сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны хөтөлбөрүүдэд элсэгчид харьцангуй тогтвортой байсан. Сэтгүүл зүйн хөтөлбөрийн элсэгчдийн бууралт зөвхөн Америк гэлтгүй бусад улс орнуудад ч ажиглагдаж байна. Тухайлбал, Шинэ Зеландын сэтгүүл зүйн ангийн оюутны тоо 2013 оноос буурч, төгсөгчид мултимедиа чадвартай байх ёстой гэсэн салбарын хүлээлтэд хүрэх ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна (Hannis 2017). Жоржиагийн их сургуулийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны коллежийн жил бүрийн сэтгүүл зүйн боловсролын чиг хандлагын дүн шинжилгээнд 2014 онд мэдээлснээр Миссуригийн их сургуулийн Сэтгүүл зүйн сургуульд (1908 онд байгуулагдсан) элсэлт 2011-2013 онд 9 хувиар буурсан бол Чикагогийн Колумбийн коллежийн элсэлт 5 жилийн хугацаанд 33 хувиар, Индианагийн Блумингтон их сургуульд таван жилийн хугацаанд 20 хувиар буурсан байна (N. S. Institute 2022).

Pew Research Center-ийн судалгаагаар уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үзэгчдийн тоо буурч байгааг харуулжээ. Тухайлбал, 2023 онд АНУ-д орон нутгийн телевиз, ихэнх сонин, нийтийн радио зэрэг уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үзэгчдийн тоо буурсан байна (Micheal Lipka 2023). Сэтгүүл зүйн оюутны тоо буурч байгаагийн томоохон шалтгаан нь ийнхүү уламжлалт сэтгүүл зүйн салбарын уналт гэж сэтгүүл зүйн судлаачид үзэж байгаа билээ. Ийнхүү олон оюутны хотхоны “мөнгөний үнээ”-ийн тоонд багтаж байсан сэтгүүл зүйн сургуулиуд сүүлийн жилүүдэд шинэ оюутнуудыг элсүүлэн сургах шинэ сорилтуудтай тулгарсан.

Судалгааны арга зүй

Монголын сэтгүүл зүйн оюутнууд сэтгүүлчийн мэргэжлийг сонгох болсон шалтгаан, сэтгүүл зүйн нөхцөл байдлын тухай ерөнхий үнэлэмж, сэтгүүл зүйн ирээдүйд итгэх итгэл, хэвлэл мэдээллийн салбарын өөрчлөлтийн тухай ойлголт, байр суурийг сэтгүүлч мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудаар тодорхойлуулах зорилгоор асуулгын судалгааг хийсэн юм. Мэргэжлийн үнэлэмж нь оюутнуудын ирээдүйн мэргэжлээ эзэмших талаарх ойлголт, хандлагад хэрхэн нөлөөлж байгааг судлах нь нэн чухал бөгөөд энэ нь тэдний ирээдүйн мэргэжлээ эзэмших, түүнийгээ эрхэмлэх хандлагад маш чухал нөлөөтэй юм. Судалгааг 8 их, дээд сургуулийн 235 оюутнаас онлайнаар 2020 оны 5 дугаар сард, мөн 8 их, дээд сургуулийн 191 оюутнаас онлайнаар 2023 оны 11 дүгээр сард авсан юм.

Судалгааны асуулт

RQ1: Монголын сэтгүүл зүйн оюутнууд мэргэжлээ хэрхэн үнэлдэг вэ?

RQ2: Сэтгүүлчээр ажиллах хүлээлтэд нөлөөлөх хүчин зүйлс юу вэ?

Тоон шинжилгээ. 2023 оны судалгаанд хамрагдсан оюутнуудын 24 /12,6%/ нь 1-р курс, 45 /23,6%/ 2-р курс, 51 /26,7%/ нь 3-р курс, 71 /37,2%/ нь 4-р курсийн оюутнууд байлаа. Тэдгээрийн 154 буюу 80,6 хувь нь эмэгтэй оюутан, 37 буюу 19.4 хувь эрэгтэй оюутан байна. Судалгаанд оролцогчдыг сургууль болон мэргэжил сонгосон шалтгаанаар нь хувьсагч хоорондын хамаарлыг үзүүлэх тоон шинжилгээний аргаар харьцуулбал, бүх сургуулиудыг өөрийн хүсэл, зорилгоор сонгожээ. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчийн мэргэжил сонголтод өөрийн хүсэл эрмэлзэл зонхилдог бөгөөд суралцаж буй сургуулиас хамаарсан хандлага харагдахгүй байна. Тэд өөрсдийн хүсэл сонирхлын дагуу (66,8%) элсэн ордог ч дийлэнх буюу 68 хувийнх нь мэргэжлийн талаарх ойлголт суралцах явцад нь өөрчлөгддөг нь 2021 оны судалгаанаас харагдаж байна.

Сэтгүүл зүйн оюутнууд өөрсдийн мэргэжлийг хэрхэн харж байгаа, их сургуулийн боловсрол тэдний ертөнцийг үзэх үзэлд хэр нөлөөлж байгааг судлав. Сэтгүүлч болох сэдлийг төрүүлэх хүчин зүйлсийг оюутнуудаар үнэлүүлэхэд, дундаж үнэлгээ хамгийн өндөр байгаа нь 4.15 оноотой буюу олон хүмүүстэй танилцах боломж гэж үзэж байна.



Зураг 1. Сэтгүүлч болох сэдлийн хүчин зүйлсийн эрэмбэ

Оюутнууд монголын сэтгүүл зүйн салбарын өнөөгийн байдлыг үнэлүүлэхэд, 2020 онд суралцаж байсан оюутнуудын 86,8% нь сэтгүүл зүйн салбарт дунд, муу гэсэн үнэлгээ өгсөн бол, 2023 онд суралцагчдын 85,9% нь дунд, муу, 9,4% нь сайн, 4,7% нь мэдэхгүй гэжээ. Дунд болон муу гэж үнэлгээ өгсөн 171 оюутны / давхардсан тоогоор/ 98 (57,3%) нь сэтгүүлчид мэдээллээ үнэн зөв, бүрэн, шударга хүргэдэггүй, 100 (58,5%) нь олон нийтэд үйлчлэх эрх ашгаа умартаж ашиг орлогоо

дээгүүрт тавьсан, 116 (67,8%) нь үзэл бодлоо тулгасан, тэнцвэргүй, мушгин гуйвуулсан мэдээлэл түгээдэг буюу ёс зүйгүй гэж дүгнэсэн байна.

“Сургуулиа төгсөөд мэргэжлээрээ ажиллах уу” гэсэн асуултад 53% нь тийм гэж хариулсан бол 41,9% нь хараахан шийдээгүй, 5,2% нь үгүй гэж хариулсан байна. Харин сэтгүүлчийн ангийн оюутнуудын дийлэнх буюу 48% нь телевиз, 17,9% нь байгууллагын олон нийттэй харилцах албанд, 13,1% нь сайтад, 11,8% нь тогтмол хэвлэлд, 1,7% нь радиод, 7,4% нь бусад салбарт ажиллана гэж хариулсан байна. Энэ дүнгээс харвал, оюутнууд телевизэд ажиллах сонирхолтой байна. Монголын 451 мэдээллийн хэрэгсэлд 4448 хүн ажиллаж, үүнээс телевизийн салбарт 2257 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 51% болж байна (Монголын хэвлэлийн хүрээлэн 2023, 2024).

Хүснэгт 3. Өнөөдрийн монголын сэтгүүлчдэд үнэлгээ өгнө үү

**Ажиллах салбар Crosstabulation³*

		Маркетингийн алба	Олон нийттэй харилцах алба	Сошиал медиа алба
Өнөөдрийн монголын сэтгүүлчдэд үнэлгээ өгнө үү	Муу	29.2%	20.8%	37.5%
	Дунд	23.5%	25.2%	24.3%
	Сайн	5.6%	5.6%	5.6%
Total		22.3%	22.3%	24.2%

Төгсөөд бусад салбарт ажиллах хүсэлтэй байгаа оюутнууд өнөөгийн сэтгүүлчдэд бага үнэлгээ өгсөн оюутнууд байна. Өөрөөр хэлбэл, нийт оюутнуудын 24,3% нь бусад салбарт ажиллах сонирхолтой байгаа бөгөөд сэтгүүлчдэд өндөр буюу сайн үнэлгээ өгсөн оюутнуудын 5% нь бусад салбарт ажиллах хүсэлтэй байна. Харин дунд, муу үнэлгээтэй оюутнуудын 20-37 хүртэлх хувь нь өөр салбарт ажиллахаа илэрхийлсэн байна.

Дээрх социологийн судалгааны дүнгээс үзвэл, мэргэжлээ өөдрөгөөр хардаг ч гэсэн салбартаа шүүмжлэлтэй хандаж байгаа оюутнуудын 40 орчим хувь нь сэтгүүл зүйн салбарыг хөдөлмөрийн нөхцөл муу гэж үнэлэн өөр мэргэжлээр суралцах сонирхолтой байна. Энэ судалгааг Монголын хэвлэлийн хүрээлэнгээс 2019 онд Улаанбаатар хот болон 19 аймгийн 260 хэвлэл мэдээллийн хэрэгслийн 1100 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдыг хамруулан хийсэн хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөл байдлын талаарх судалгаатай харьцуулан үзэхэд, оюутнуудын ойлголт бодит байдлаас хол зөрөөгүй байна.

Ажиллагсдын дийлэнхийг 26-35 насны залуус эзэлдэг энэ салбарын өрхийн дундаж орлого улсын дунджаас доогуур байна. Сэтгүүлчдийн гэр бүлийн 77%-ийн өрхийн орлого хүрэлцдэггүй аж. ҮСХ-оос 2019 оны 1 дүгээр улиралд ажиллагсдын сарын дундаж цалин 990 мянган төгрөг (татварын дараах) гэж тогтоосон бол хэвлэл мэдээллийн салбарынх 664 мянган төгрөг байна. Ажиллагсдын 92% нь дээд боловсролтой ч улсын дунджаас 30 гаруй хувь доогуур цалин авдаг юм байна. Сэтгэл ханамжийн байдлын хувьд хамт олны уур амьсгалдаа сэтгэл ханамжтай,

³ Эх сурвалж: Асуулгын судалгааны дүн

харин цалиндаа сэтгэл ханамж муу байна. Ажиллагсдын 60 орчим хувь нь цалин бага, цалингаа өгдөггүй, өсөх ирээдүй муутай, хамт олон даргатай зөрчилтэй гэсэн шалтгаанаар 1-4 удаа ажлаа сольсон, тогтвор суурьшил муутай ажилладаг байна. Ажиллагсдын 76% нь өөрийгөө хөгжүүлэх, сургалтад суух хүсэлтэй ч санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг (49%) аж. Ажлын цагийн хувьд салбарын ажиллагсад өдөрт дунджаар 9.1 цаг 7 хоногийн 6.5 өдөрт ажилладаг. Долоо хоногийн 7 өдрийн зөвхөн хагас өдрийг нь гэр бүлтэйгээ өнгөрөөх боломжтой, хэвлэл мэдээллийн салбар гэр бүлд ээлтэй бус салбар юм байна. Салбарын ажиллагсдын талаас илүү хувь нь нийтээр амрах өдрүүдээр ажилласан бол нөхөн амарч чаддаггүй (62%), цалингаа нөхөн авч чаддаггүй (60%), мөн ээлжийн амралтаа эдэлж чаддаггүй, эдэлж ч үзээгүй ажиллагсад олон байна (Фридрих Эбертийн сан 2019).

Регрессийн шинжилгээ. Оюутнуудын төгсөөд мэргэжлээрээ ажиллах хүлээлтэд нөлөөлөгч ач холбогдол бүхий хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор олон хувьсагчийн регрессийн шинжилгээ хийлээ. Мэргэжлээрээ ажиллах эсэхэд суралцаж буй их, дээд сургууль хамааралгүй байсан бөгөөд хамааралтай байж болзошгүй хувьсагчдаар хүйс, суралцаж буй түвшин буюу курс, өнөөгийн сэтгүүлчдэд өгсөн үнэлгээ, нийгмийн зүгээс ирэх дарамт болон нийгмийн үнэлэмж зэрэг гадаад хүчин зүйлсийг нэгтгэн дээрэлхэл нэртэй чанарын хувьсагч үүсгэн үнэлэхэд хүйсээс бусад хувьсагчууд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан тул хүйсийг хасаж дараах хүснэгтэд регрессийн шинжилгээний үр дүнг тодорхойллоо.

Хүснэгт 4. Регрессийн шинжилгээний үнэлэгдсэн коэффициентүүд⁴

Загвар	Стандарт бус коэффициент		Стандарт коэффициент	t	Sig.
	B	Std. Error	Beta		
(Constant)	.563	.179		3.154	.002
Bully	-.187	.085	-.177	-2.197	.030
Та хэддүгээр курст суралцдаг вэ?	-.093	.040	-.187	-2.338	.021
Өнөөдрийн монголын сэтгүүлчдэд үнэлгээ өгнө үү	.131	.057	.186	2.316	.022
а. Хамааралтай хувьсагч: Төгсөөд сэтгүүлч мэргэжлээрээ ажиллах уу?					

Регрессийн шинжилгээний үр дүнд дараах тэгшитгэлд харуулсан бөгөөд тэгшитгэлд “Мэргэжил”-ээр тухайн оюутан ирээдүйд сэтгүүлч мэргэжлээр ажиллана гэсэн хүлээлттэй эсэхийг илэрхийлж буй хувьсагч хэрвээ оюутан мэргэжлээрээ ажиллана гэсэн бол 1, мэргэжлээрээ ажиллахгүй бол 0 гэсэн утга авна, “Түвшин”-ээр суралцаж буй түвшин, “Үнэлгээ”-ээр өнөөгийн монголын сэтгүүлчдэд өгсөн үнэлгээ, хувьсагчийн утга өсөх тусам үнэлгээ сайжирна, bully-ээр нийгмийн зүгээс ирэх дарамт, олон нийтийн үнэлэмж зэрэг гадаад хүчин зүйлээр үүсгэсэн хувьсагч.

⁴ Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

$$\text{Мэргэжил} = 0.56 - 0.09\text{түвшин} + 0.13\text{үнэлгээ} - 0.18\text{дээрэлхэл}$$

$$n = 147, R^2 = 0.59$$

Бидний боловсруулсан загвар буюу оюутны мэргэжлээрээ ажиллах хүлээлтэй байгаа эсэхэд суралцаж буй түвшин, сэтгүүлч мэргэжлийн үнэлэмж, нийгмийн зүгээс ирэх дарамт зэргийг нөлөөлнө хэмээн авч үзэж эдгээр хувьсагчуудаас хамааруулан авч үзсэн регрессийн загвар нь бүхэлдээ ач холбогдолтой болохыг F статистик, түүнд харгалзах ач холбогдлын түвшнээс харж болно (Хүснэгт 5). Мөн эдгээр 3 хүчин зүйл нь мэргэжлээрээ ажиллах хүлээлтийн нийт хэлбэлзлийн 59%-ийг тайлбарлаж байгааг R квадрат буюу детерминацийн коэффициент харуулж байна. Level буюу тухайн оюутан курс ахих тусам мэргэжлээрээ ажиллах хүлээлт буурч байна, коэффициентийн утга нь -0.09 байгаа нь оюутан 1 түвшнээр өндөр курст сурдаг байх нь мэргэжлээрээ ажиллах хүлээлтийг 0.09-өөр бууруулна гэсэн дүгнэлт гарч байгаа бөгөөд p утга < 0.05 тул 95%-ийн ач холбогдолтой байна. Evaluation буюу өнөөгийн сэтгүүлчдэд өгсөн үнэлгээ өсөх тусам оюутны мэргэжлээрээ ажиллах хүлээлт нэмэгдэж байна, коэффициентийн утга нь 0.13 байгаа нь эерэг нөлөөтэйг харуулж байна мөн p утга < 0.05 тул 95%-ийн ач холбогдолтой байна. Bully нь оюутнуудыг мэргэжлээрээ ажиллах хүлээлтийг 0.18-аар бууруулж байна, p утга < 0.05 тул 95%-ийн ач холбогдолтой байна. Энэхүү загварын хувьд оюутны мэргэжлээрээ ажиллана гэсэн хүлээлтийг мэргэжлээрээ ажиллах магадлал гэж үзээд бүхэлд нь тайлбарлавал сэтгүүлч мэргэжлээр суралцаж буй оюутнууд курс ахих тусмаа мэргэжлээрээ ажиллах магадлал 9%-иар буурч байна. Evaluation буюу өнөөгийн сэтгүүлчдэд өгсөн үнэлгээ өсөх тусам оюутны мэргэжлээрээ ажиллах хүлээлт 13%-аар нэмэгдэж байна. Bully нь оюутнуудыг мэргэжлээрээ ажиллах хүлээлтийг 18%-аар бууруулж байна.

Хүснэгт 5. Регрессийн загварын үр дүн: ANOVA⁵

Загвар		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
1	Регресс	3.429	3	1.143	4.903	.003 ^b
	Үлдэгдэл	33.565	144	.233		
	Бүгд	36.993	147			
а. Хамааралтай хувьсагч: Төгсөөд сэтгүүлч мэргэжлээрээ ажиллах уу?						
б. Урьдчилсан таамаглал: (Тогтмол), Өнөөдрийн монголын сэтгүүлчдэд үнэлгээ өгнө үү, Та хэддүгээр курст суралцдаг вэ? Дээрэлхэл						

Хэлэлцүүлэг

Энэ зуунд сэтгүүл зүйн боловсрол дижитал эринд дасан зохицох шаардлагатай болж байна. Уламжлалт сэтгүүл зүйн хөтөлбөрүүд нь дижитал ур чадвар, сошиал медиа сэтгүүл зүй, үзэгчдийн оролцоог хангах чиглэлээр хамрах хүрээгээ тэлж байна. Хөтөлбөрүүд нь оюутнуудыг сонин, сэтгүүлээс эхлээд онлайн мэдээллийн хэрэгсэл, подкаст хүртэл янз бүрийн платформ дээр ажиллахад бэлтгэх хэрэгтэй болжээ.

⁵ Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Орчин үеийн сэтгүүл зүйн боловсрол нь сэтгүүлчийн ур чадварыг эзэмшүүлэхээс гадна сэтгүүл зүйн ёс зүй, олон талт байдал, нийгэмд хувьсан өөрчлөгдөж буй сэтгүүл зүйн үүргийн талаар гүнзгий ойлголт өгөх явдал юм. Эдгээр хөтөлбөрүүд нь сэтгүүлчдийг төдийгүй сэтгүүл зүйн хурдацтай хөгжиж буй ертөнцөд хөгжих чадвартай, мэдээлэлтэй, хариуцлагатай, дасан зохицох чадвартай хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилготой юм.

Хэвлэл мэдээллийн орчинд нөлөөлж буй эдгээр хурдацтай өөрчлөлтөд сэтгүүл зүйн боловсрол хэрхэн дасан зохицох вэ? Өнөөдөр мэргэжлийн сэтгүүлчдэд тулгараад байгаа асуудлуудын нэг хэсэг нь редакцуудад учирч буй улс төр, эдийн засгийн дарамт, хуурамч мэдээ, үзэгчдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл багассан явдал юм. Сэтгүүл зүйн үнэнийг мэдээлэх нь тэргүүн зэргийн ач холбогдолтой байх нь мэдээж. Гэхдээ янз бүрийн платформ дээрх мэдээллийг удирдахад уян хатан байдал, дасан зохицох чадварыг хөхиүлэн дэмжих, хамгийн сүүлийн үеийн технологийн хэрэгслүүдийг хамгийн сайн ашиглах тухай юм. Бизнес эрхлэх болон техникийн ур чадвар нь оюутнуудад олон хэлбэрийн мэдээлэл бүтээх, олон нийтийн дэмжлэг авах, мөнгө босгох үйл ажиллагаатай холбоотой стратегиудыг эзэмшүүлэх, мэргэжлийн хөдөлгөөнт байдалд дасах, өөрсдийн хэвлэл мэдээллийн бизнесийн санаачилгыг төлөвлөхөд нь дэмжлэг үзүүлэх, мөн ёс зүйн үнэт зүйлсийг сануулж байх ёстой. Технологийн хэрэглээ, хүмүүсийн мэдээллийг хүлээж авах зан төлөв, мэдээ бэлтгэх, хүлээн авахтай холбоотой уламжлалт аргууд сорилт бий болгож буй өнөөгийн нөхцөлд хэвлэл мэдээлэл амжилтад хүрэхийн тулд уян хатан байдал, дасан зохицох чадвар байх болно.

Монголын сэтгүүл зүйн оюутнуудын сэтгүүлчийн мэргэжлийг сонгох шийдвэр, салбарын нөхцөл байдал, ажлын байрны хүлээлт нь хоёр жилийн хугацаанд бага зэрэг өөрчлөгдсөн хэдий ч, сэтгүүл зүйн салбарын ирээдүйн төлөв байдлын талаарх оюутнуудын итгэл, сэтгэгдэл сөрөг хэвээр байгааг илрүүлсэн. Энэ нь монголын сэтгүүл зүйн салбарт үүссэн олон асуудал, тэр дундаа ёс зүйн болон мэргэжлийн хувьд гарч буй сорилтуудыг шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

Сэтгүүл зүйн сургуулиуд хөдөлмөр эрхлэлтийн загвар, хүлээн авагчидтай харилцах харилцааны хувьд хурдацтай өөрчлөгдөж буй энэ мэргэжлээр оюутнуудыг хэрхэн бэлтгэх талаар хэлэлцэж байна. Өнөөгийн хурдацтай өөрчлөгдөж буй хэвлэл мэдээллийн орчинд ажиллах оюутнууд нь бизнес эрхлэх, мэдээг түгээх, санхүүжүүлэхэд нийгмийн сүлжээг ашиглах, гар утасны төхөөрөмжийг сургалтын үндсэн хэрэгсэл болгон ашиглах, медиа платформын ард байгаа алгоритмуудыг ойлгож, илүү сонирхолтой визуал болон интерактив түүх ярих боломжийг олгох компьютерын програмчлалын ур чадварыг эзэмших шаардлагатай болжээ.

Дижитал хувьсгал уламжлалт мэдээллийн хэрэгслийг хүчээр шахаж байгаа тул оюутны тоо мэдэгдэхүйц буурч байна. Мөн олон нийт төдийгүй, сэтгүүлчээр суралцаж байгаа оюутнууд салбартаа сэтгэл дундуур байгаа нь элсэлт буурахад нөлөөлжээ. Эцэст нь, баримтад тулгуурлан мэдээлж, ёс зүйн үндсэн үнэт зүйлсэд үнэнч байхын чухлыг онцлон тэмдэглэж байна. Энэ нь сэтгүүлч мэргэжилд итгэх

итгэлийг сэргээх цорын ганц боломж юм. Өөрөөр хэлбэл, итгэл үнэмшилгүй болсон олон нийтийн сэтгүүл зүйд итгэх итгэлийг сэргээхийн тулд баримтад тулгуурласан сэтгүүл зүй, чанартай эрэн сурвалжилга, тэнцвэртэй мэдээллийг дэмжих үндсэн дүрэм рүүгээ буцах ёстой болжээ. Ийнхүү сэтгүүл зүйн үндсэн үнэт зүйлсийг бууруулахгүй байснаар ардчилсан нийгмийг төлөвшүүлэхийн тулд сэтгүүлчид үнэнийг хэлэх, иргэдэд үнэнч байх, нийтэлж буй зүйлээ сайтар шалгах, бие даасан байдлаа хадгалах, эрх мэдлийг хянах, олон нийтийн шүүмжлэлд өртөх талбар болж, хүлээн авагчдад сонирхолтой, хэрэгцээтэй мэдээллийг хүргэх үүрэг хариуцлагыг хүлээх ёстой. Харин их, дээд сургуулиуд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь боловсролын шинэчлэлийн үр дүнтэй стратеги байх боломжтой.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Баасансүрэн, Т., Мөнхзориг, Н., Дагиймаа, Э. нар. 2017. “Сэтгүүл зүйн мэргэжлийн шүүмжлэгчдийг бэлтгэх хэрэгтэй.” 2025.03.15. <https://www.polit.mn/a/24046>

Дэлхийн банк. 2013. *Монголын дээд боловсрол: дэлхийн эдийн засгийн өнөөгийн асуудлууд*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Зулькафиль, М. 2014. *Сэтгүүлчийн мэргэжил*. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Норовсүрэн, Л. 2001. *Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Норовсүрэн, Л. 2003. *Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Монголын хэвлэлийн хүрээлэн. 2013. *Монголын хэвлэл мэдээлэл - өнөөдөр*. Улаанбаатар: Чөлөөт хэвлэл сан.

Монголын хэвлэлийн хүрээлэн. 2024. *Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр 2023*. Улаанбаатар: Чөлөөт хэвлэл сан.

Сэтгүүл зүй олон нийтийн харилцааны тэнхим. 2020. *Сэтгүүл зүйн тэнхим-60 жилд*. Улаанбаатар: Адмон принт ХХК.

Фридрих Эбэрт сан. 2019. *Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлын судалгааны тайлан*. Монголын хэвлэлийн хүрээлэн. <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/15695.pdf>. 2025.03.15.

Гадаад хэлээр:

Becker, L.B., Vlad, T., & Simpson, H. 2014. “2013 Annual Survey of Journalism Mass Communication Enrollments.” *Journalism & Mass Communication Educator*, 69(4): 345. <https://doi.org/10.1177/1077695814555432>.

Dagiima, D. 2016. *Model curricula for Mongolian journalism education: its vision and reforms in the new, democratic period*. Oakland. URL: <https://wjec2.wjec.net/refereed-proceedings.html>.

- Hannis, G. 2017. "Journalism Education in New Zealand: Its History, Current Challenges and Possible Futures." *Journalism and Mass Communication Educator*, 27(2): 328. <https://doi.org/10.1177/1326365X17728823>.
- Melissa R. Gotlieb, Bryan McLaughlin, R. Glenn Cummins. 2017. *2015 Survey of Journalism and Mass Communication Enrollment: Challenges and Opportunities for Changing and Diversifying Field*. <https://doi.org/10.1177/1077695817698612>.
- National Student Clearinghouse research center. 2022. "Undergraduate Enrollment Falls 662,000 Students in Spring 2022 and 1.4 Million During the Pandemic." 2025.03.15. <https://www.studentclearinghouse.org/nscblog/undergraduate-enrollment-falls-662000-students-in-spring-2022-and-1-4-million-during-the-pandemic/>.